



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар A/93

Бодь

Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а" Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай Засгийн газрын 221 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/526 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сумын хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах 2022-2023 оны нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Өвөл хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах сумын нэгдсэн төлөвлөгөөг тулгуурлан хэрэгжилтийг хангуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.2022-2023 оны өвөлжилт хаваржилтын байдал хүндэрч болзошгүй тул сумын хэмжээний аюулгүй нөөцийн өвс тэжээлийг бэлтгэх, мал, мах худалдан борлуулах судалгааг гаргах ажлыг хангахад арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж төлөвлөгөөний хэрэгжилт, явцын тайлан мэдээг 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Б.Баяраа), (Б.Алтанхуяг) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201177

Сумын Засаг даргын 2022 оны 08 дугаар
сарын 28 -ны өдрийн 142 тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН СУМ БАГИЙН ӨВӨЛЖИЛТИЙН
БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүд

Б.Алтанхуяг

(Хөдөө аж ахуйн тасгийн үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн)

Б.Баяраа

(Хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

А.Лхагвабаяр

(Мал эмнэлгийн тасгийн дарга)

Г.Эрдэнэтөр

(Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйц)

Ж.Лхагвасүрэн

(Уу булан 1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Наранбаатар

(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг

(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат


(Цагаан ус 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганцэцэг

(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)

оОо

Сумын Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22 -ны өдрийн 193 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2022-2023 ОНЫ
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4
1	Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах	09 сарын 05-ний дотор	Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар
2	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино болон дунд хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын улирлын урьдчилсан төлөв байдлын талаарх мэдээ, мэдээллээр иргэд, малчдыг тогтмол хангах, өвөл хаврын улирлын бэлчээрийн даацыг бодитой тогтоон өвөлжилт, хаваржилтын зураглал гарган хариу арга хэмжээг авч ажиллах	10,11,12, 1, 2 сард	Цаг уурын харуул, Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар
3	Малчин өрх бүрийг мал сүрэгтээ тарга хүч авхуулах малын хашаа хороо, худаг уст цэгээ засварлах тохижуулах, өвс тэжээл, хадлан, гар тэжээл, түлээ түлш, хоол хүнс, өвлийн хувцсаа бэлтгэх зэргээр өвөлжилтийн бэлтгэлийг эртнээс хангуулах	11 дүгээр сарын 01- ний дотор	Багийн Засаг дарга нар
4	Өвөл хаврын улирлын бэлчээрийн даацад тохируулан малын тоог бууруулах, малын чанар сүргийн бүтцийн зохистой харьцаанд тулгуурлан малыг эдийн засгийн эргэлтэд оруулж мал мах бэлтгэлийн ажлыг зохион байгуулах	12 дугаар сарын 25-ний дотор	Багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг
5	Сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх / сум 100 тн өвс, 40 тн тэжээл /	9,10,11,12 сард	Засаг даргын тамгын газар, хөдөө аж ахуйн тасаг
6	Малчин өрх бүр хонин толгойд шилжүүлснээр 1 малд 5 өдрөөр тооцож өвс 5 кг, тэжээл 1кг –ыг бэлтгэж нөөцлөх	9,10,11, 12 сард	Багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг

1	2	3	4
7	Отрын бүс нутаг болон өөр нутагт оторлох мал сүргийг мэндийн үзлэг шинжилгээ, угаалга, туулга вакцинд бүрэн хамруулж, тууврын замд хяналт тавих.	9,10 сард	Багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг
8	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулах, хяналт тавих.	9,10 сард	Багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг,
9	Малчин өрхийн жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0-5 насны хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	10,11,12, 1, 2 сард	Багийн Засаг дарга нар, Багийн эмч нар, Хөдөө аж ахуйн тасаг
10	Отроор өвөлжих, хаваржих малчин өрхийн судалгаа гаргаж малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах	9,10, 11, 12,	Багийн Засаг дарга нар, Нийгмийн даатгалын байцаагч, Хөдөө аж ахуйн тасаг
11	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах	9, 10, 11 сард	Багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг
12	Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих хяналтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг малчид, иргэдэд сурталчлах арга зүйгээр хангаж ажиллах.	10,11,12, 1, 2 сард	Мал эмнэлгийн тасаг, Багийн Засаг дарга нар,
13	Сумын хэмжээнд 2022-2023 онд өвөлжих болон хэрэгцээлэх малын тоог малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тохируулан нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах.	11,12, 1 сард	Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар